



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 11 сарын 03 өдөр

Дугаар 558

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах зөвшөөрөл
олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын харьяа байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 295,705,700.00 (хоёр зуун ерэн таван сая долоон зуун таван мянга долоон зуун) төгрөгийн балансын үнэ бүхий 10 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Т.Гантулга болон харьяа газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, бүртгэх;

2.4. Худалдсан автомашиныг улсын бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2020 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн
558 дугаар тогтоолын хавсралт

**МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН
ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ
АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ**

№	Суудлын автомашин, улсын дугаар, арлын дугаар	Үйлдвэрлэсэн/ашиглалтанд орсон он	Балансын нийт үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газар				
1	Тоёота Прадо, улсын дугаар 51-09 БНХ, арлын дугаар RZJ1200012964	2003/2012	33,000,000.00	3,000,000.00
2	Хьюндай Старекс, улсын дугаар 44-70 БНХ, арлын дугаар KMJWWN7HP5U639048	2005/2012	18,000,000.00	1,000,000.00
Говь-Алтай аймгийн Мэргэжлийн хяналтын газар				
3	Фургон улсын дугаар 85-08 ГАА арлын дугаар 90003964	2010/2010	18,527,000.00	1,500,000.00
Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газар				
4	Мицубиши Пажеро, улсын дугаар ДГО 84-24, арлын дугаар JMYLNV96W8J003827	2008/2008	43,750,000.00	1,500,000.00
5	Мицубиши Пажеро, улсын дугаар ДГС 16-84, арлын дугаар JMYLNV96W8J003807	2008/2008	43,750,000.00	500,000.00
Орхон аймгийн Мэргэжлийн хяналтын газар				
6	Фургон, улсын дугаар ОРХ 12-99, арлын дугаар 60489942	2005/2006	14,652,000.00	2,500,000.00
7	Хьюндай Старекс, улсын дугаар ОРО 88-84, арлын дугаар KMJWWN7HP6U700120	2006/2013	12,485,000.00	800,000.00
Увс аймгийн Мэргэжлийн хяналтын газар				
8	Мицубиши Л-200, улсын дугаар УВХ 69-82, арлын дугаар MMBJNKB40BD022432	2011/2011	58,436,100.00	2,500,000.00
Хүнсний Аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори				
9	Хьюндай Старекс Н-1, улсын дугаар УНС 69-14, арлын дугаар KMFWBX7RACU33556	2011/2012	36,500,000.00	3,800,000.00
Замын-Үүд Хилийн мэргэжлийн хяналтын алба				
10	Фургон, улсын дугаар УБЛ 57-91, арлын дугаар 70427807	2007/2008	16,605,600.00	1,000,000.00
			295,705,700.00	14,100,000.00
11	Дүн		(Хоёр зуун ерэн таван сая долоон зуун таван мянга долоон зуун төгрөг)	(Арван дөрвөн сая нэг зуун мянга)